

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-171-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/23 хуудас NZ Part 171-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.5-д үндэслэсэн /</i></p>	<p>Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллага - үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт <i>NZ Part 171-ийн 1996 оны 02 сарын 08-ны А.1-д үндэслэсэн</i> <i>Хүчинтэй мөрдөгдөж байгаа 2002 оны /17 хуудас/</i></p>	<p>Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>171.1 Зорилго Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) <u>нисэхийн холбоо, навигац,ажиглалтын техник үйлчилгээ болон тухайн байгууламжийн</u> үйл ажиллагааны болон техникийн стандарт; (2) IFR нислэгт, эсхүл НХҮ-нд дэмжлэг үзүүлдэг нисэхийн холбоо, <u>навигац,ажиглалтын техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны.</u></p>	<p>171.1. Зорилго / Purpose (а) Энэ дүрмийн зорилго нь Иргэний нисэхийн салбарын хэмжээнд <u>Агаарын навигацийн үйлчилгээ</u>, түүний байгууламжуудын үйл ажиллагааны болон техникийн шаардлагуудыг тогтоох; мөн хэрэглэлийн нислэгийн дүрмээр (IFR) үйлдэх нислэгт болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд Агаарын навигацийн үйлчилгээг үзүүлэх техникийн байгууллагыг гэрчилгээжүүлэх, түүний үйл ажиллагааг зохицуулах журмуудыг тогтооход оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>171.3 Нэр томъёо болон товчлол <u>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</u></p>	<p>171.3. Тодорхойлолт / Definitions</p>	<p>- Нэр томъёоны тайлбар,тодорхойлолтууд ИНД-1-д орсон.</p>
<p>171.5 Гэрчилгээний шаардлага (а) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын (цаашид “АНТҮБ” гэх) гэрчилгээний эрх болон нөхцөлд заагаагүй нисэхийн холбоо, навигац,ажиглалтын техник навигацийн үйлчилгээ үзүүлэхгүй, эсхүл <u>нисэхийн байгууламжийг ажиллуулахгүй байх үүрэгтэй.</u></p>	<p>171.5. Гэрчилгээжүүлэх шаардлага/ Requirement for certificate (а) Энэ дүрмийн дагуу гэрчилгээжсэн байгууллага болон аливаа этгээд нь энэ зүйлийн (б), (в) хэсэгт зааснаас бусад тохиолдолд агаарын навигацийн үйлчилгээний байгууламжийг ажиллуулахыг <u>хориглоно.</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

(b) Хэрэв этгээд нь нисэхийн радио давтамж дээр нисэхийн байгууламжийг ажиллуулдаг ба дараах шаардлагыг хангасан бол энэ зүйлийн (a) нь хамаарахгүй:

(1) тухайн нисэхийн байгууламж нь:

- (i) НХҮ-нд дэмжлэг үзүүлдэггүй радио холбооны дамжуулагч бол; эсхүл
- (ii) IFR нислэгт, эсхүл НХҮ-нд дэмжлэг үзүүлдэггүй радио навигацийн туслах төхөөрөмж бол;

(2) тухайн нисэхийн байгууламж нь дараах шаардлагын дагуу ажилладаг бол:

- (i) ICAO-гийн Хавсралт 10, Volume III, Part II, Chapter 2, эсхүл Хавсралт 10, Volume I, Chapter 3-т заасан холбогдох системийн үзүүлэлт;
- (ii) ICAO-гийн Хавсралт 10, Volume II-т заасан холбогдох холбооны журам;

(3) тухайн нисэхийн байгууламж нь бусад нисэхийн холбоо, навигаци ажиглалтын техник үйлчилгээ үйлчилгээний, эсхүл нисэхийн байгууламжид нөлөөлдөггүй бол;

(4) Дарга тухайн нисэхийн байгууламжид радио төхөөрөмж ашиглах эрх олгосон бол;

(5) тухайн нисэхийн байгууламжид 171.17-гийн дагуу таних код, эсхүл дуудлага олгосон бол.

(c) Хэрэв этгээд нь нисэхийн радио давтамж дээр газрын хөдөлгөөнт радиог ажиллуулдаг ба дараах шаардлагыг хангасан бол энэ зүйлийн (a) нь хамаарахгүй:

(1) тухайн радио холбооны төхөөрөмжийг НХҮ-нд

(б) Гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд нь нисэхийн радио давтамжинд ажилладаг дараах нөхцөл шаардлагыг хангасан байгууламжийг ажиллуулж болно:

1/ тухайн байгууламж нь ашиглалтын хувьд:

- 1.1. нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдахгүй радио холбооны дамжуулагч бол;
- 1.2. хэрэглэлийн нислэгийн дүрмээр (IFR) үйлдэх нислэг, эсхүл нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдахгүй радио навигацийн байгууламж бол;

2/ тухайн байгууламж нь стандарт, шаардлагуудын хувьд:

- 2.1. Чикагогийн конвенцийн Хавсралт 10, 3 дугаар боть, 2 дугаар хэсэг, 2 дугаар бүлэг эсхүл Хавсралт 10, 1 дүгээр боть, 3 дугаар бүлэгт заасан систем тодорхойлолтуудыг хангасан бол;
- 2.2. Чикагогийн конвенцийн Хавсралт 10, 2-р ботид заасан холбооны журмуудаар тогтоосон шаардлагыг хангасан бол ;

3/ тухайн байгууламж нь агаарын навигацийн бусад үйлчилгээ болон байгууламжийн үйл ажиллагаанд нөлөөлдөггүй бол;

4/ тухайн байгууламжид эрх бүхий байгууллагаас дараах зөвшөөрлийг олгосон бол:

- 4.1. радио давтамжийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас олгосон тухайн байгууламжийг ажиллуулах давтамжийн зөвшөөрөл;
- 4.2. энэхүү дүрмийн 171.103-т заасны дагуу авсан тухайн байгууламжийн таних тэмдэг болон радио дуудлага.

(в) Энэ дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд нь нисэхийн радио давтамжинд ажилладаг газрын хөдөлгөөнт радио дамжуулагчийг дараах шаардлагыг хангасан нөхцөлд ажиллуулж болно:

<p>дэмжлэг үзүүлэхэд ашигладаггүй бол;</p> <p>(2) тухайн радио нь ICAO-гийн Хавсралт 10, Volume II-т заасан холбогдох холбооны журмын дагуу ажилладаг бол;</p> <p>(3) тухайн радио дамжуулалт нь бусад нисэхийн холбоо, навигаци ажиглалтын техник үйлчилгээ, эсхүл нисэхийн байгууламжид нөлөөлдөггүй бол;</p> <p>(4) Дарга тухайн радио төхөөрөмж ашиглах эрх олгосон бол.</p>	<p>1/ тухайн радио дамжуулагч нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдахгүй;</p> <p>2/ тухайн радио дамжуулагч нь Чикагогийн конвенцийн Хавсралт 10, 2 дугаар ботид заасан холбооны журмуудын шаардлагуудыг хангасан;</p> <p>3/ радио дамжуулалт нь агаарын навигацийн бусад үйлчилгээ болон байгууламжийн үйл ажиллагаанд нөлөөлдөггүй;</p> <p>4/ радио давтамжийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас радио давтамжийн зөвшөөрөл авсан бол.</p>	
<p>171.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах АНТЕБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24171/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар;</p> <p>(2) хэрэв хамааралтай бол, 171.17-д шаардсан таних код, эсхүл дуудлага авах хүсэлт;</p> <p>(3) хэрэв хамааралтай бол, зохих төлбөрийн баримт.</p>	<p>171.7. Өргөдөл гаргах/ Application for certificate (а) Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээг эзэмшихээр өргөдөл гаргагч /цаашид “өргөдөл гаргагч” гэх/ нь ИНЕГ-171/01 маягтыг бөглөж, дараах бичиг баримтуудын хамтаар ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ энэ дүрмийн 171.79-д заасан өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны заавар;</p> <p>2/ шаардлагатай тохиолдолд төлбөрийн баримт.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.1-ээр нэмэгдсэн</p> <p>- Ерөнхий заавар нь үйл ажиллагааны заавраас тусдаа</p>
<p>171.9 Гэрчилгээ олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагчид энэ Дүрмийн дагуу АНТҮБ-ын гэрчилгээг олгох үүрэгтэй:</p> <p>(1) хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлага хангасан байх;</p> <p>(2) хүсэлт гаргагч болон 171.51(а)(1), (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;</p> <p>(3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</p>	<p>171.9. Гэрчилгээг олгох/ Issue of certificate (а) ИНЕГ-ын дарга нь өргөдөл гаргагч дараах шаардлагыг хангасан тохиолдолд түүнд агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээг олгоно:</p> <p>1/ өргөдөл гаргагч нь энэ дүрмийн Б бүлэгт заасан шаардлагыг хангасан;</p> <p>2/ өргөдөл гаргагч, түүний удирдах албан тушаалтнууд нь энэ дүрмийн 171.51 (а) 1/ болон 2/-т заасан шаардлагад нийцсэн;</p> <p>3/ гэрчилгээ олгосноор иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзэж байгаа бол;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>171.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх (а)АНТҮБ-ын гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчийг IFR нислэгт, эсхүл НХҮ-нд дэмжлэг үзүүлж ажиллахыг</p>	<p>171.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх (а) Гэрчилгээ эзэмшигч нь Хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэгт болон нислэгийн</p>	

<p>зөвшөөрсөн нисэхийн холбоо, навигаци ажиглалтын техник үйлчилгээ болон нисэхийн байгууламжийн төрлийг заана.</p> <p>(b) Энэ Дүрмийн 171.113-ыг харгалзан, АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд заасан нисэхийн байгууламжийн төрлийг дараах тохиолдолд ажиллуулж болно:</p> <p>(1) ажиллуулж байгаа нисэхийн байгууламж бүрийг гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан; эсхүл</p> <p>(2) хэрэв тухайн нисэхийн байгууламжийг Ерөнхий заавартаа заагаагүй бол, түүний үйл ажиллагааг талбайн тест хийх зорилгоор 171.53(b)-д шаардсан журмаар хянадаг байх.</p>	<p>хөдөлгөөнд Агаарын навигацийн холбоо, навигаци, ажиглалтын үйлчилгээг Гэрчилгээнд тусгагдсаны үзүүлэх эрхтэй.</p> <p>(б) Энэ дүрмийн 171.109 зүйлд хамааралтайгаар Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээ эзэмшигч (цаашид Гэрчилгээ эзэмшигч гэх) нь гэрчилгээний дагуу дараах байгууламжуудыг ажиллуулж болно:</p> <p>1/ гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт тусгагдсан бол;</p> <p>2/ хэрэв байгууламж нь Үйл ажиллагааны зааварт тусгагдаагүй бол энэ дүрмийн 171.53-д заасны дагуу түүний ажиллагаанд хяналт тавьж, техникийн туршилт, шалгалт хийж байгаа бол;</p> <p>(г) Гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргад холбогдох баталгааг гарган өгч, гэрчилгээний эрхийг сэргээлгэх хүсэлтээ тавьж болно.</p>	
	<p>171.11. <u>Агаарын навигацийн үйлчилгээний төрөл</u></p> <p>(a) <u>Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын гэрчилгээнд эрхлэх Агаарын навигацийн үйлчилгээний төрөл, тухайн төрлийн үйлчилгээг эрхлэхэд тавигдах шаардлагыг тусгасан байх ба үйлчилгээний төрлийг дараах ангиллаар тогтооно:</u></p> <p><u>1/ нисэхийн мэдээллийг нэвтрүүлэх үйлчилгээ:</u></p> <p><u>1.1. нислэг үйлдэж буй агаарын хөлөгт өгөх цаг агаарын мэдээ (VOLMET);</u></p> <p><u>1.2. мэдээллийн автомат систем (ATIS).</u></p> <p><u>2/ нисэхийн суурин холбооны үйлчилгээ:</u></p> <p><u>2.1. нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний шууд ярианы хэлхээ;</u></p> <p><u>2.2. нисэхийн суурин холбооны сүлжээ (AFTN);</u></p> <p><u>2.3. төв хоорондын холбоо (ICC);</u></p> <p><u>2.4. ICAO-гийн өгөгдөл харилцан солилцох ерөнхий сүлжээ (CIDIN);</u></p> <p><u>2.5. нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний өгөгдөл дамжуулах үйлчилгээ (ATS message handling);</u></p> <p><u>2.6. цаг уурын мэдээллийн цахилгаан холбооны</u></p>	

	<p><u>сүлжээ.</u></p> <p><u>3/ нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээ:</u></p> <p><u>3.1 богино долгионы агаар-газар холбоо(HF);</u></p> <p><u>3.2 хэт богино долгионы агаар-газар холбоо(VHF);</u></p> <p><u>3.3 ультра богино долгионы агаар-газар холбоо(UHF);</u></p> <p><u>3.4 агаар-газар өгөгдлийг солилцогч.</u></p> <p><u>4/ нисэхийн радио навигацийн үйлчилгээ:</u></p> <p><u>4.1. хэрэглэлээр буулт үйлдэх систем (ILS);</u></p> <p><u>4.2. буулт үйлдэх хэт богино долгионы систем (MLS);</u></p> <p><u>4.3. бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч (VOR);</u></p> <p><u>4.4. чиглүүлэх радио нэвтрүүлэгч (NDB);</u></p> <p><u>4.5. зай хэмжих төхөөрөмж (DME);</u></p> <p><u>4.6. маркерын радио нэвтрүүлэгч (Marker radio beacon);</u></p> <p><u>4.7. нарийвчлалтай ойртолтын радиолокатор (PAR);</u></p> <p><u>4.8. ажиглалтын хоёрдогч радиолокатор (SSR);</u></p> <p><u>4.9. автоматаар чиглэл тогтоогч (ADF)</u></p> <p><u>4.10. ил харааны ойртолтын налуу заагч систем (PAPI);</u></p> <p><u>4.11. гэрэл суултын систем (AFL).</u></p> <p><u>5/ нисэхийн ажиглалтын үйлчилгээ:</u></p> <p><u>5.1. ажиглалтын анхдагч радиолокатор;</u></p> <p><u>5.2. ажиглалтын хоёрдогч радиолокатор;</u></p> <p><u>5.3. автомат хамааралтай ажиглалтын систем(ADS);</u></p> <p><u>5.4. тооцоот ажиглалтын систем(Multilateration).</u></p> <p><u>6/ Монгол Улсын агаарын навигацийн системийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бусад үйлчилгээ:</u></p> <p><u>6.1. цахилгаан хангалтын үндсэн болон бэлтгэл үүсгүүр.</u></p>	
<p>171.13 Гэрчилгээний хугацаа</p> <p>(a) АНТҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.</p> <p>(b) АНТҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.</p> <p>(c) АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд</p>		<p>-Орхигдуулсан заалт нөхөж оруулсан</p>

<p><u>Даргад</u> нэн даруй хураалгах үүрэгтэй.</p> <p>(d) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр <u>Даргад</u> нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.</p>		
<p>171.15 Гэрчилгээ сунгах</p> <p>(a) АНТҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24171/01 маягтын дагуу гаргах ёстой.</p> <p>(b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол тухайн гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө <u>Даргад</u> хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>171.17. Гэрчилгээний хугацааг сунгах/ Renewal of certificate</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гэрчилгээг сунгуулах өргөдлийг ИНЕГ-171/01 маягтын дагуу гаргаж, төлбөрийн баримтын хамт <u>ИНЕГ-ын даргад</u> ирүүлнэ.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч гэрчилгээнд заагдсан үйл ажиллагаа, үйлчилгээг хэвийн үргэлжлүүлэх шаардлагыг хангасан тохиолдолд <u>ИНЕГ-ын дарга</u> гэрчилгээг энэ дүрмийн <u>171.15-ын</u> (a)-д заасан хугацаагаар сунгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p><u>171.17 Таних код болон дуудлага</u></p> <p><u>(a)Аливаа этгээд дараах шаардлага хангаагүй төхөөрөмжийг ажиллуулахгүй:</u></p> <p><u>(1)энэ зүйлийн (c)-гийн дагуу Дарга таних код олгосноос бусад радио навигацийн туслах төхөөрөмж; эсхүл</u></p> <p><u>(2)энэ зүйлийн (c)-гийн дагуу Дарга дуудлага олгосноос бусад тохиолдолд, 171.5(c)-д зааснаас бусад нисэхийн радио давтамж дээр ажилладаг радио холбооны дамжуулагч.</u></p> <p><u>(b)Энэ зүйлийн (a)-гийн дагуу таних код, эсхүл дуудлага авах хүсэлт гаргагч нь САА 24171/02 маягтыг бөглөж, Даргад хүргүүлэх үүрэгтэй.</u></p> <p><u>(c)Хэрэв Дарга тухайн код, эсхүл дуудлага олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй гэж үзвэл, Дарга радио навигацийн туслах төхөөрөмжид таних код, эсхүл радио холбоо дамжуулах нисэхийн байгууламжид дуудлага олгож болно.</u></p>		<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>171.19. Нисэхийн байгууламжийн мэдээллийг хүргүүлэх</p> <p>Нисэхийн байгууламж ажиллуулж байгаа этгээд нь дараах арга хэмжээг цаг алдалгүй авах үүрэгтэй:</p> <p>(1) НМҮ-ний байгууллагад дараах мэдээллийг</p>		<p>- Amend.1-аар нэмэгдсэн</p>

<p>дамжуулах:</p> <p>(i) AIP-д хэвлэн нийтлүүлэх зорилгоор, тухайн нисэхийн байгууламжийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(ii) NOTAM гаргах зорилгоор, тухайн нисэхийн байгууламжийн үйл ажиллагааны төлөв байдалд орсон аливаа өөрчлөлтийн мэдээлэл.</p> <p>(2) хэрэв хамааралтай бол, энэ хэсгийн (1)-ийн дагуу дамжуулсан мэдээлэл нь үнэн зөв хэвлэн нийтлэгдсэн болохыг хянах.</p> <p>(3) түгээгдсэн мэдээллийн зөрчлийг ИНД-12-ын дагуу Даргад мэдээлэх.</p>		
	<p>171.19. <u>Дүрмийн шаардлагаас чөлөөлөх</u> <u>(а) ИНЕГ-ын дарга нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан нөхцөлд ИНД-11-ийн холбогдох заалтыг үндэслэн, гэрчилгээ эзэмшигчийг энэ дүрмийн зарим шаардлагаас чөлөөлж болно.</u></p>	<p>- Amend.3-аар хасагдсан</p>
<p>171.21 <u>Нисэхийн байгууламжийн хангах мэдээлэл</u> <u>Нисэхийн байгууламж ажиллуулж байгаа этгээд нь хэрэв тухайн байгууламжийн хангаж байгаа мэдээлэл нь алдаатай гэж сэжиглэж байгаа, эсхүл сэжиглэх шалтгаан байгаа бол, тухайн байгууламжийг үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрөхгүй байх үүрэгтэй.</u></p>		<p>- Нэмэлтээр орсон</p>
<p>В Бүлэг. Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ШААРДЛАГУУД</p>	
<p>171.51. <u>Ажилтанд тавих шаардлага</u> (а) АНТУБ-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</u> (1) <u>Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон</u> дараах үүрэгтэй удирдах ажилтан: (i) тухайн байгууллагын гүйцэтгэж байгаа бүх үйл ажиллагааг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан</p>	<p>171.51. <u>Хүний нөөцөд тавигдах шаардлага/ Personnel requirements</u> (а) <u>Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагын</u> гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна: 1/ байгууллагын бүх үйл ажиллагаа нь энэ дүрмийн шаардлагад нийцэж, санхүүжигдэж байгааг бататгах, хяналт тавих, энэхүү бүлэгт заасан шаардлагуудыг биелүүлж, хариуцлага хүлээх <u>эрх бүхий удирдах албан</u> тушаалтан;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.1-аар нэмэгдсэн</p>

<p>шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах;</p> <p>(ii) тухайн байгууллага нь энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартыг хангаж байгааг бататгах;</p> <p>(2) <u>Гүйцэтгэх захирлын</u> өмнө дараах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтан болон удирдах ажилтнууд:</p> <p>(i) тухайн хүсэлт гаргагчийн байгууллага нь <u>Ерөнхий</u> заавраа дагаж мөрдөж байгааг бататгах;</p> <p>(ii) 171.73-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;</p> <p>(3) <u>Ерөнхий</u> заавартаа заасан байгууламжид үзлэг хийх, хянах болон засвар хийх хангалттай тооны ажилтан.</p> <p>(aa) Энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнууд нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, <u>туршлагаа харуулсан</u> байх үүрэгтэй.</p> <p>(b) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий</u> заавартаа заасан байгууламжийг ашиглалтад эрхийг тухайн гэрчилгээ эзэмшигч олгосон ажилтанд зориулсан дараах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>эрх бүхий ажилтны</u> ур чадварт үнэлгээ хийх;</p> <p>(2) <u>эрх бүхий ажилтны</u> ур чадварыг хадгалах;</p> <p>(3) <u>эрх бүхий ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.</u></p>	<p>2/ байгууллага, түүний нэгж, салбаруудын үйл ажиллагаа энэ дүрмээр тогтоосон шаардлагуудыг хангаж байгааг бататгах, хянах үүрэг хүлээсэн энэ зүйлийн (a) 1/-т заасан удирдах албан тушаалтанд шууд захирагдах албан тушаалтнууд;</p> <p>3/ <u>өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан байгууламжуудын ажиллагааг шалгах, хянах, ажиллуулахад мэргэшсэн эрх, үүрэг бүхий бэлтгэгдсэн ажилтнууд.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> байгууллагын сургалтын бодлогыг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж мөрдөх ба ажилтнуудын сургалт, дадлагажуулалт, ур чадварын <u>бүртгэлийн сантай</u> байна.</p> <p>(в) <u>Өргөдөл гаргагч нь сургалтын үйл ажиллагааг ICAO-гийн Doc 7192-ын AN/857-ын E-2 хэсэг болон Doc 9683 заавруудын дагуу зохион байгуулна.</u></p> <p>(г) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмуудыг боловсруулж ажилтнуудын эрх, үүргийг бичгээр баталгаажуулсан байна:</p> <p>1/ <u>мэргэжлийн</u> ур чадварыг үнэлэх;</p> <p>2/ <u>мэргэжлийн</u> ур чадварыг хадгалах, <u>дээшлүүлэх, мэргэжлийн үнэмлэх олгох;</u></p>	
<p>171.53 <u>Нисэхийн</u> байгууламжийн шаардлага</p> <p>(a) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:</p>	<p>171.53. <u>Агаарын навигацгийн үйлчилгээний</u> байгууламжид тавигдах шаардлага</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангахуйц баталгаажуулсан журмыг тогтоосон байна:</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан нисэхийн байгууламж нь:
- (i) тухайн байгууламжийн холбогдох үйл ажиллагааны тодорхойлолтод нийцэхээр зохион бүтээгдсэн, суурилагдсан ба ашиглалтад орсон байх;
 - (ii) ICAO-гийн Хавсралт 10 Volumes I, III болон IV-т заасан тохирох системийн үзүүлэлт болон тодорхойлолтын стандартыг хангасан байх;
 - (iii) D Бүлгийн холбогдох техникийн тодорхойлолт болон шаардлагыг хангасан байх;
 - (iv) хэрэв код, эсхүл дуудлагыг 171.17-д шаардсан бол, таних код, эсхүл дуудлага олгосон байх;
- (2) аэродромд ойртолт, буулт болон хөөрөлт үйлдэхэд зайлшгүй шаардлагатай, хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан радио навигацийн туслах төхөөрөмжийн үйл ажиллагааны төлөв байдлын мэдээллийг дараах НХУ-ын нэгжийн үйл ажиллагааны хэрэгцээг хангах зорилгоор хүргүүлсэн байх:
- (i) үйлчилгээ үзүүлж байх үедээ, тухайн аэродромыг аэродромын удирдлагын үйлчилгээгээр хангадаг;
 - (ii) үйлчилгээ үзүүлж байх үедээ, тухайн аэродромыг ойртолтын удирдлагын үйлчилгээгээр хангадаг;
- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан нисэхийн байгууламж бүрийг НХУ, эсхүл радио навигацийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлж байгаа холбогдох үйл ажиллагааны

- 1/ үйл ажиллагааны зааварт тусгагдсан байгууламж нь:
- 1.1. техникийн ашиглалтын шаардагдах үзүүлэлтийг хангасан маяг, загвар, суурилуулалттай байх ба зохих шаардлагыг хангасан тохиолдолд түүнийг ашиглалтанд хүлээн авна;
 - 1.2. Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын I, III, IV-р боть болон Хавсралт 14-ийн I-р ботид заасан стандарт, шаардлага, системийн холбогдох үзүүлэлтийг бүрэн хангасан байна;
 - 1.3. 171.103 дугаар зүйлд дурьдсан таних тэмдэг, радио дуудлага авсан байна; 1.4. байгууламжийн ажиллах радио давтамж нь Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын V Хэсэгт заасан шаардлагыг хангахаас гадна ИНЕГ-ын радио давтамжийг хуваарилах, хамгаалах бодлоготой нийцсэн байх ба харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас радио давтамжийн зөвшөөрлийг авсан байна.
- 2/ Үйл ажиллагааны зааврын дагуу аэродромд ойртолт, хөөрөлт ба буулт үйлдэхэд ашиглагддаг радио навигацийн үйлчилгээний байгууламжийн ажиллагааны мэдээллийг дараах газруудад хүргэдэг байна:
- 2.1. аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд;
 - 2.2. ойртолтын нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд.
- 3/ Үйл ажиллагааны зааврын дагуу ажиллуулах байгууламж бүрийг нисэхийн радио навигацийн үйлчилгээ болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний шаардлагад нийцсэн,

- тасралтгүй байдлыг бататгах зорилгоор тохиромжтой цахилгаан тэжээлийн эх үүсвэр болон арга хэлбэрээр хангасан байх;
- (4) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан нисэхийн байгууламжийг эвдэх, гэмтээх, эсхүл үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа эрсдэлийг багасгах зорилгоор 171.55-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн дагуу суурилуулсан байх;
- (5) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан нисэхийн байгууламжийн эрсдэлтэй ажлын талбай бүрийг:
- (i) тухайн нисэхийн байгууламжийн ажлын талбайн зурагт тодорхой заасан байх;
- (ii) тухайн ажлын талбайд тохирох бичгэн тэмдэглэгээгээр хамгаалсан байх;
- (iii) тухайн ажлын талбайн хориг, хязгаарлалт нь барилга, хашаа, тээврийн хэрэгсэл, машин төхөөрөмж, эсхүл агаарын хөлгөөр зөрчигдөхгүй байхыг бататгах зорилгоор тухайн ажлын талбайн өмчлөгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгч болон НХУ-ын нэгжийн аль холбогдох байгууллагатай бичгээр гэрээ байгуулж хамгаалсан байх.

(b) Талбайн тест хийх зорилгоор нисэхийн түр байгууламж ажиллуулахыг зорьж байгаа АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн тестийг хийх журмыг тогтоосон байх үүрэгтэй.

тасралтгүй ажиллагааг хангах цахилгаан тэжээлийн зохиx эх үүсвэртэйгээр суурилагдсан байна;

4/ байгууламжийн ажиллагаанд саад учруулах, эвдлэн сүйтгэх зэргээс үүсэх эрсдэлийг хамгийн бага байлгахын тулд энэ дүрмийн 171.55 дугаар зүйлд заасанчлан Аюулгүй байдлын хөтөлбөрт тусгагдсанаар суурилагдсан байна;

5/ Үйл ажиллагааны зааварт заасан байгууламж бүрийн байрлалын онцгой бүсийг:

5.1. тухайн байгууламжийн байрлалын зурагт тодорхой тэмдэглэгдсэн байна;

5.2. тухайн байрлалд зохиx тэмдэг, тэмдэглэгээг хийж, хамгаалагдсан байна;

5.3. байрлалын хязгаарлалтын бүсэд аливаа барилга, хашааг барих, тээврийн хэрэгсэл болон агаарын хөлгөөр дайрч сүйтгэх зэргээс сэргийлж тухайн газар, объектыг эзэмшигч, аэродромын үйл ажиллагааг эрхлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний төвтэй бичгээр гэрээг байгуулж хамгаалсан байна.

(б) Үйл ажиллагааны зааварт заагдсан Агаарын навигацийн үйлчилгээний байгууламжууд нь дараах нэмэлт үзүүлэлт, шаардлагыг хангасан байна:

1/ өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны зааварт заагдсан радио навигацийн байгууламж бүр нь хяналтын системтэй байх ба дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн төхөөрөмжийн ажиллагааг үйлчилгээнээс тусгаарлаж, холбогдох удирдлага хяналтын цэг рүү анхааруулах мэдээллийг дамжуулдаг байна:

1.1. тухайн төхөөрөмжийн хангаж байгаа навигацийн мэдээлэл нь зөвшөөрөгдсөн нарийвчлалын хэмжээнээс гадна

(c) Энэ зүйлийн (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:

- (1) тухайн түр байгууламжийн үйл ажиллагаа нь бусад нисэхийн байгууламжийн үйл ажиллагаанд нөлөөлөх шалтгаан болдоггүй байх;
- (2) тухайн түр байгууламжийн үйл ажиллагааны талаарх шаардлагатай мэдээллийг NOTAM гаргах, хэрэв AIP-ын Нэмэлт хавсралтаар хэвлэн нийтлэх нь тохиромжтой бол НМУ-ний байгууллагад хүргүүлдэг байх;
- (3) зохих NOTAM хэвлэн нийтэлдэг байх.

буюу хэтэрсэн;

1.2. таних тэмдгийн (ID) дамжуулалтад алдаа заасан;

1.3. хяналтын системд гэмтэл, саатал үүссэн.

2/ цахилгаан тэжээлийн үндсэн болон бэлтгэл үүсгүүр нь Чикагогийн конвенцийн Хавсралт 14-ын I боть, 8 дугаар бүлэгт заасан стандарт, шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.1. радио навигацийн байгууламжуудын цахилгаан тэжээлийн сэлгэн залгалтын хугацаа нь аэродромын зэрэглэлээс хамаарах ба нисэх буудлуудад байрладаггүй бие даасан радионавигацийн байгууламжуудын цахилгаан тэжээлийн сэлгэн залгалтын хугацаа нь Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын I боть, Хавсралт C-гийн 8.1-т заагдсан шаардлага хангасан;

2.2. хэрэв цахилгаан хангамжийн бэлтгэл үүсгүүр автоматаар холбогддоггүй бол, шаардлагатай үед аль болох хурдан шилжүүлэн залгах аргачлалыг тодорхойлсон байх.

(в) Өргөдөл гаргагч нь байгууламжийг түршилт хийх зорилгоор түр ажиллуулах бол дараах шаардлагыг бататгасан журмыг боловсруулж мөрдөнө:

1/ түр ажиллуулж буй байгууламжийн ажиллагаа нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд ашиглагдаж байгаа бусад байгууламжийн ажиллагаанд нөлөөлөхөөргүй байх;

2/ түр ажиллуулж буй байгууламжийн ажиллагааны холбогдолтой мэдээллийг нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (AIS)-д дамжуулж NOTAM мэдээгээр зарлуулсан байх ба хэрэв шаардлагатай бол Нисэхийн мэдээллийн эмхэтгэл /AIP/-д хэвлүүлсэн байх;

3/ байгууламжид түршилт, техникийн шалгалтыг хийхийн өмнө хор хөнөөл учруулахуйц сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх.

	<p>(г) <u>Агаарын навигацийн үйлчилгээний байгууламж нь ИНЕГ-ын даргаас баталгаажуулсан гэрчилгээжүүлэх журмын дагуу ашиглалтанд тэнцэхийг нотолсон гэрчилгээ авсан байна.</u></p> <p>(д) <u>Агаарын навигацийн үйлчилгээний байгууламжийг зөвхөн ашиглалтанд тэнцэх гэрчилгээ олгогдсоны дараа агаарын навигацийн үйлчилгээнд ашиглана.</u></p> <p>(е) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт заагдсан байгууламжийн техник үйлчилгээ, засварт ашиглагдах сэлбэгийн хангалтын талаар дараах үйл ажиллагааг зохицуулах журмыг боловсруулж мөрдөнө.</u></p> <p><u>1/ байгууламжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор байгууламж тус бүрд шаардлагатай сэлбэг хэрэгслийн жагсаалтыг эрх бүхий ажилтнаар гаргуулах, хянуулах, батлуулах болон сэлбэгийн жагсаалтын дагуу сэлбэгийг захиалах, худалдан авах түүнд хяналт тавих;</u></p> <p><u>2/ худалдан авахаас өмнө бүрэн гүйцэд үзлэг хийх боломжгүй эд анги, сэлбэг хэрэгслүүд нь чанарын шаардлага хангаж буй эсэхийг бататгах аргачлалыг тодорхойлсон байх;</u></p> <p><u>3/ байгууламжийн сэлбэг хэрэгслийг хүлээн авах, тэдгээрийн хадгалалт, хаяглалт зэрэгт тавигдах шаардлагуудыг нарийвчлан тогтоосон байх;</u></p> <p><u>4/ байгууламжийн сэлбэг хэрэгслийн бүртгэл, тэдгээрийн олголт, сэлбэг хэрэгслийн зарцуулалтын тайлан тооцоог гаргах аргачлалыг заасан байх;</u></p>	
<p>171.55. Аюулгүйн <u>хамгаалалтын</u> хөтөлбөр</p> <p>(а) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан байгууламжийн аюулгүйн хамгаалалтын <u>хөтөлбөрийг</u> хэрэгжүүлсэн байх үүрэгтэй.</u></p> <p>(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан аюулгүйн <u>хамгаалалтын</u> хөтөлбөрт <u>эвдрэл, гэмтэл, эсхүл хууль бус үйлдэл нь тухайн <u>агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд АНТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд ажиллаж байгаа нисэхийн</u></u></p>	<p>171.55. Аюулгүй <u>байдлын</u> хөтөлбөр/ <u>Security programme</u></p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа тусгагдсан байгууламжуудыг <u>хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад чиглэсэн</u> аюулгүй <u>байдлын</u> хөтөлбөртэй байна.</u></p> <p>(б) Аюулгүй <u>байдлын</u> хөтөлбөрт, байгууламжуудын ажиллагаанд саад учруулах, эвдлэн <u>сүйтгэх</u> зэргээс үүсэх <u>эрсдлийг хамгийн бага байлгахад</u> чиглэсэн дараах аюулгүй байдлын шаардлага, түүнийг</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.3-аар нэмэгдсэн</p>

<p><u>байгууламжийн үйл ажиллагааны эвдрэл, гэмтэл, эсхүл хууль бус үйлдлийн эрсдэлийг багасгах зорилгоор аюулгүйн хамгаалалтын бодит шаардлага, дадлага сургуулилт болон журмыг заасан байх ёстой.</u></p> <p>(с) <u>Энэ зүйлийн (а)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дараах шаардлагыг бататгах зорилгоор шаардлагатай байж болох аюулгүйн хамгаалалтын бодит шаардлага, дадлага сургуулилт болон журмыг багтаасан байх ёстой:</u></p> <p>(1) <u>зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх зорилгоор нисэхийн байгууламж бүр нь байнга нэвтрэх хяналттай болохыг бататгадаг</u> байх;</p> <p>(2) нисэхийн байгууламжийг <u>гэмтээх тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл бусад заналхийллийн үед ажилчид дагаж мөрддөг</u> байх;</p> <p>(3) <u>хяналтгүй орхисон нисэхийн байгууламжийн байранд хууль бусаар нэвтрэх</u>, эсхүл үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдлийг <u>шуурхай илрүүлдэг болохыг бататгах зорилгоор хяналт тавьдаг</u> байх.</p> <p>(d) Энэ зүйлийн (а)-д шаардсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр нь аюулгүйн хамгаалалтын зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу <u>Даргад</u> мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлан гаргах журмыг багтаасан байх ёстой.</p>	<p>Биелүүлэх үйл ажиллагааг тусгасан байна.</p> <p>1/ өргөдөл гаргагчийн Үйл ажиллагааны зааварт заагдсан агаарын навигацийн барилга, байгууламжийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн 6-р зүйлд заасны дагуу хамгаалагдсан бүсэд байрлуулах ба нисэх буудлуудад байрладаггүй бие даасан <u>радионавигацийн байгууламжуудыг нь хамгаалалтын бүстэй байх</u>;</p> <p>2/ байгууламжийг суурьлуулсан барилга нь аливаа <u>халдлага, саад учруулах ажиллагааг шуурхай илрүүлэх хяналтын системтэй</u> байх, эсхүл Монгол улсын <u>Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн дагуу зөвшөөрөл авсан харуул хамгаалалтын байгууллагаар хамгаалуулсан байх</u>;</p> <p>3/ байгууламжид хөндлөнгийн <u>хууль бус үйлдэл, халдлага</u> гарсан тохиолдолд <u>ажилтнуудын ажиллах журмыг тогтоож мөрдөх</u>;</p> <p>(в) Аюулгүй байдлын холбогдолтой аливаа зөрчлийг ИНД-12-т заасны дагуу мэдээлэх, <u>ИНЕГ</u>-т илтгэж байх.</p>	
<p>171.57. Баримт бичиг</p> <p>(а) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан байгууламжийн хангалт болон үйл ажиллагаанд шаардагдах холбогдох <u>төхөөрөмжийн заавар</u>, техникийн стандарт, <u>практик</u>, <u>зааварчилгаа</u> болон бусад баримт бичгийн хувийг хадгалдаг байх үүрэгтэй.</u></p> <p>(б) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> энэ зүйлийн (а) болон холбогдох бусад Дүрэмд шаардсан</p>	<p>171.57. Бичиг баримтжуулалт/ <u>Documentation</u>.</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> заавартаа тусгасан байгууламжуудын ажиллагаанд шаардлагатай техникийн баримт бичиг, ашиглалтын болон, засвар үйлчилгээний заавар, техникийн стандартууд, холбогдох бусад бичиг баримттай байна.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> энэ зүйлийн (а)-д заагдсан бичиг баримтуудыг хянах журамтай байх ба уг журам нь</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>баримт бичгийг хянах журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(с) <u>Энэ зүйлийн (b)-д шаардсан журам нь дараах шаардлагыг багтаасан байх ёстой:</u></p> <p>(1) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө 171.51-д заасан холбогдох удирдах ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;</p> <p>(2) нисэхийн байгууламжийн хангалт болон үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох бүх баримт бичгийн хүчинтэй хувийг тухайн баримт бичиг шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад <u>бэлэн байлгах</u>;</p> <p>(3) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй <u>хураан авдаг</u> байх;</p> <p>(4) баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийг 171.51-д заасан эрх бүхий албан тушаалтан хянаж, <u>баталгаажуулдаг</u> байх;</p> <p>(5) <u>хугацаа нь дууссан хэвлэлтийг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.</u></p>	<p>дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <p>1/ бүх бичиг баримтыг ашиглахаас өмнө 171.51-д заагдсан эрх бүхий албан тушаалтан хянаж, зөвшөөрсөн байх;</p> <p>2/ байгууламжийн ажиллагаа, ашиглалтанд шаардлагатай холбогдох бичиг баримтыг хянаж, зөвшөөрөгдсөн хувийг тухайн ажлын байранд ажиллах хүмүүс авч бүрэн ашиглах <u>боломжтой</u> байх;</p> <p>3/ хүчингүй болсон бичиг баримтыг ажлын байр болон хэрэгцээнээс нэн даруй гаргаж <u>мөрдүүлэхгүй</u> байх;</p> <p>4/ бичиг баримтад оруулж байгаа нэмэлт өөрчлөлтүүдийг энэ дүрмийн 171.51 зүйлд заасан эрх бүхий албан тушаалтан хянаж, <u>зөвшөөрсөн</u> байх.</p>	
<p>171.59 Хуваарьт үзлэг шалгалт болон тест хийх</p> <p>(а) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь,</u> нисэхийн байгууламж бүрийг тухайн байгууламжийн холбогдох үйл ажиллагааны шаардлага болон техникийн үзүүлэлтийн тодорхойлолтыг хангасан болохыг бататгах, <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> зааварт заасан нисэхийн байгууламжид хуваарьт <u>үзлэг</u> шалгалт болон <u>тест</u> хийх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) <u>Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:</u></p> <p>(1) газрын үзлэг шалгалт, <u>тест</u>, хэрэв шаардлагатай бол шалгалтын нислэгийн багтаасан байх;</p> <p>(2) дараах мэдээллийг <u>харгалзан</u>, <u>Ерөнхий</u> зааварт заасан нисэхийн байгууламж бүрийн хуваарьт <u>тестийн</u> хоорондох үечлэлийг тогтоох, эсхүл өөрчлөх шалгуурыг багтаасан байх:</p> <p>(i) ICAO-гийн <u>хэвлэн нийтэлдэг</u> холбогдох мэдээлэл;</p>	<p>171.59. Хугацаат хэмжилт ба шалгалт тохируулга</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> зааварт заагдсан байгууламжуудын хэвийн ажиллагааны зохих шаардлага, <u>техникийн үзүүлэлтүүдийг</u> хангаж бататгах, хуваарьт <u>техникийн хэмжилт</u>, шалгалт <u>тохиргоо</u> хийх ажлыг зохицуулсан журамтай байх ба энэ журам нь дараах зүйлийг агуулсан байна:</p> <p>1/ <u>байгууламжийн</u> газрын шалгалт <u>тохиргоо</u>, <u>хэмжилт</u> болон шаардлагатай бол хийгдэх нислэгээр гүйцэтгэх шалгалт <u>тохируулга</u>;</p> <p>2/ байгууламжид дараах мэдээллүүдийг үндэслэн гүйцэтгэх хуваарьт шалгалт, хэмжилтийн давтамжийг тогтоох, өөрчлөх шалгуурууд;</p> <p>2.1 ICAO-гоос гаргасан холбогдох мэдээлэл;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(ii) тухайн <u>нисэхийн</u> байгууламжийн холбогдох найдвартай <u>ажиллагааны</u> өгөгдөл;</p> <p>(iii) тухайн нисэхийн байгууламж болон бусад ижил төрлийн нисэхийн байгууламжийн батлагдсан найдвартай ажиллагааны үзүүлэлтийн мэдээлэл болон тухайн нисэхийн байгууламжийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчны тогтвортой байдлын мэдээлэл;</p> <p>(3) <u>Ерөнхий зааварт заасан нисэхийн</u> байгууламж бүрийн хуваарьт <u>тестийн</u> хоорондох үечлэлийг тогтоох, эсхүл өөрчлөх үндэслэлийг баримтжуулсан болохыг бататгасан байх.</p>	<p>2.2 тухайн байгууламжийн найдвартай ажиллагааны холбогдох өгөгдөлүүд;</p> <p>2.3 тухайн байгууламжийн эсхүл ижил төрлийн байгууламжийн найдвартай ажиллагааны шалгагдсан мэдээлэл, тухайн байгууламжийн ажиллах орчны тогтвортой байдал.</p> <p>3/ тухайн байгууламжийн хуваарьт шалгалт <u>тохиргоо</u>, хэмжилтийн давтамжийг тогтоох ба өөрчлөх үндэслэлийг баримтжуулсан байх;</p> <p>4/ <u>хэмжилтийг зөвхөн энэ дүрмийн 171.51-д заасан этгээд гүйцэтгэх;</u></p> <p>5/ <u>шалгалт тохиргоог тухайн байгууламжийн шалгалт тохиргоог хийх сургалтанд хамрагдаж, эрх авсан этгээд гүйцэтгэх.</u></p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>
<p>(b) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> зааварт заасан нисэхийн байгууламж бүрийн хуваарьт газрын үзлэг шалгалтын хөтөлбөр;</p> <p>(2) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий</u> зааварт заасан нисэхийн байгууламж бүрийн хуваарьт <u>газрын тестийн</u> хөтөлбөр;</p> <p>(3) тухайн нисэхийн байгууламжийн хувьд, <u>агаарын навигацийн аюулгүй байдалд нөлөөлөхгүйгээр</u> хуваарьт <u>газрын тест нь</u> хуваарьт шалгалтыг нислэгийн орлож чадахыг энэ зүйлийн (b)(2)-т заасан шалгуураар хүсэлт гаргагч тогтоож чаддаг байхаас бусад тохиолдолд, <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан радио навигацийн туслах төхөөрөмж бүрийн</u> хуваарьт шалгалтыг нислэгийн хөтөлбөр.</p>	<p>(б) <u>Өргөдөл гаргагч нь байгууламжийн техник ашиглалтын</u> дараах хөтөлбөрүүдийг боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ:</p> <p>1/ <u>үйл ажиллагааны</u> зааварт заагдсан байгууламж бүрт хийх хуваарьт Газрын шалгалт тохиргооны хөтөлбөр;</p> <p>2/ <u>үйл ажиллагааны</u> зааварт заагдсан байгууламж бүрт тогтмол хуваарийн дагуу хийгдэх <u>Техникийн хэмжилтийн</u> хөтөлбөр;</p> <p>3/ <u>үйл ажиллагааны</u> зааварт заагдсан байгууламж бүрт хийх хуваарьт <u>Шалгалтын</u> нислэгийн хөтөлбөр.</p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>
<p>(d) Энэ зүйлийн (c)(2) болон (c)(3)-т шаардсан хөтөлбөр нь энэ зүйлийн (b)(2)-т шаардсан шалгуурт үндэслэсэн байх ёстой ба нисэхийн байгууламж бүрийн шалгалт хоорондын <u>максимум</u> үечлэлийг тогтоосон байх ёстой.</p>	<p>(в) Энэ зүйлийн (б)-гийн 2/ ба 3/-т дурьдсан, тогтмол хуваарийн дагуу хийгдэх техникийн хэмжилтийн хөтөлбөр ба Шалгалтын нислэгийн хөтөлбөр нь энэ</p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>

<p>(е) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> хуваарьт шалгалтын нислэг хийх шаардлагагүй радио навигацийн туслах төхөөрөмжийг Даргад мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>зүйлийн (а)- гийн 2/-т заасан шалгуурт үндэслэх бөгөөд байгууламжийн шалгалт <u>тохиргоо болон хэмжилт</u> хоорондын <u>хамгийн их</u> хугацааг тодорхойлсон байна.</p> <p>(г) <u>Өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын</u> даргад хуваарьт Шалгалтын нислэг хийх шаардлагагүй радио навигацийн төхөөрөмжийн талаар мэдэгдэнэ.</p> <p>(д) <u>ИНЕГ-ын дарга нь Шалгалтын нислэгт тавигдах шаардлагыг тогтооно.</u></p> <p>(е) <u>Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (д)-д заасан шаардлагыг хангасан шалгалтын нислэгийг гүйцэтгэх эрх бүхий гадаадын болон дотоодын байгууллагаар Шалгалтын нислэгийг гүйцэтгүүлнэ.</u></p> <p>(ж) <u>Чикагогийн конвенцийн Хавсралт 10-ын I Хэсэг, 3 дугаар бүлэгт заагдсан радио навигацийн төхөөрөмжүүдэд хугацаат газрын болон шалгалтын нислэгийн шалгалт тохируулгыг заавал хийнэ.</u></p>	
<p>171.61. <u>Нисэхийн</u> байгууламжийн техникийн <u>үзүүлэлт</u> <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах тохиолдолд, <u>Ерөнхий</u> заавартаа заасан нисэхийн байгууламжийг <u>ашиглалтад шилжүүлдэг</u> байхыг бататгах журмыг <u>тогтоосон</u> байх үүрэгтэй:</p> <p>(1) <u>нисэхийн</u> байгууламжийг <u>ашиглалтад оруулах</u> этгээд нь 171.51(b)-д шаардсаны дагуу ур чадварын үнэлгээ хийлгэж, <u>эрх олгогдсон</u> байх;</p> <p>(2) 171.107-д шаардсан <u>техникийн ашиглалт болон үйлчилгээний зааварчилгаанд дэлгэрэнгүй заасан <u>зохих</u></u> шалгалтыг тухайн нисэхийн байгууламжийн техникийн үзүүлэлтийг бататгах зорилгоор хийсэн байх;</p> <p>(3) тухайн <u>нисэхийн</u> байгууламжийн бүртгэлийг 171.71-д шаардсан журмын дагуу <u>хөтөлсөн</u> байх.</p>	<p>171.61. Байгууламжийн <u>ажиллагаа</u></p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангаагүй нөхцөлд <u>Үйл ажиллагааны</u> заавартаа заагдсан байгууламжуудыг ажиллуулахгүй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг <u>боловсруулан</u> гаргасан байна:</p> <p>1/ байгууламжийг <u>ажиллуулах</u> этгээд нь <u>зохих зөвшөөрөлтэй</u>, энэ дүрмийн 171.51–ийн (г)-д заасны дагуу ур чадвараа үнэлүүлсэн байх;</p> <p>2/ энэ дүрмийн 171.105-р зүйлд заасны дагуу тухайн байгууламжийн ажиллах чадварыг бататгах <u>техникийн үзлэг, шалгалтыг хийсэн</u> байх;</p> <p>3/ байгууламжийн талаарх мэдээллийн бүртгэл нь энэ дүрмийн 171.71 зүйлд заасан журмын дагуу <u>хийгдсэн</u> байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>171.63. <u>Үзлэг</u> шалгалт, хэмжилт болон <u>тестийн</u> төхөөрөмж</p> <p>(а) <u>АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> холбогдох <u>үзлэг</u> шалгалт, хэмжилт болон <u>тестийн</u> төхөөрөмжийг <u>Ерөнхий</u> заавартаа заасан <u>нисэхийн</u> байгууламж бүрийн <u>үйл ажиллагааг хэвийн явуулах</u></p>	<p>171.63. Шалгалт <u>тохируулга</u>, хэмжилтийн төхөөрөмж</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> заавартаа заагдсан байгууламж бүрийн ашиглалтыг <u>хариуцсан нэгжийг шаардлагатай</u> шалгалт тохиргоо, хэмжилтийн төхөөрөмж, <u>багажаар хангасан байна.</u></p>	

ажилтнууд авч хэрэглэх боломжтой болохыг бататгах үүрэгтэй.

(b) АНТҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэмжилт болон тест хийхэд шаардлагатай төхөөрөмж бүр оновчтой ба нарийвчлалтай болохыг бататгах зорилгоор энэ зүйлийн (a)-д шаардсан бүх үзлэг шалгалт, хэмжилт болон тестийн төхөөрөмжийг хянах, тохируулах болон хадгалах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(c) Энэ зүйлийн (b)-д шаардсан журам нь техникийн эрсдэлтэй үзүүлэлтийг хэмжихэд шаардагдах тестийн төхөөрөмж бүр дараах шаардлага хангасан болохыг бататгах ёстой:

(1) хэрэглэхийн өмнө, эсхүл тогтоосон үечлэлд, холбогдох үндэсний стандартад нийцүүлэн тохируулгыг эргэн тогтоох боломжтой хэлбэрээр хийдэг байх;

(2) тохируулгын төлөв байдлыг тохиромжтой хэлбэрээр таньж тогтоох боломжтой байх;

(3) дараах хяналтыг хийдэг байх:

(i) тохируулгын тохиргоо тохиргоо алдагдахаас хамгаалах;

(ii) тухайн тестийн төхөөрөмжийн арчилгаа, удаан хугацааны хадгалалтад шилжүүлэх болон хадгалалт нь түүний нарийвчлал болон ашиглахад тохиромжтой байдлыг хэвээр хадгалж байгаа болохыг бататгах.

(d) Хэрэв нисэхийн байгууламжийн техникийн үзүүлэлтийн тестийг хийхэд техник хангамж болон програм хангамж ашигладаг бол, нисэхийн байгууламжийн үнэн көв техникийн үзүүлэлтийг бататгах чадвартай шалгах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор энэ зүйлийн (b)-д заасан журам нь дараах нөхцөлд шалгах тогтолцооны ажиллагааг шалгахыг шаарддаг байх ёстой:

(1) ашиглалтад шилжүүлэхээс өмнө;

(б) Өргөдөл гаргагч нь хэмжилт, шалгалтыг гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмжийн нарийвчлалыг баталгаажуулах зорилгоор энэ зүйлийн (a)-д заагдсан бүх шалгалт тохиргоо, хэмжилтэд ашиглагдах төхөөрөмжүүдийн хяналт, тохируулга болон ашиглалтын үйл ажиллагааг тусгасан журмыг боловсруулж мөрдөнө.

(в) Энэ зүйлийн (б)-д заасан журмаар байгууламжийн ажиллагааны чухал өгөгдлүүдийг хэмжих төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна.

1/ ашиглахаас өмнө эсхүл тогтмол хуваарийн дагуу зохих стандартад нийцүүлэн тохируулга хийгдсэн байна. Хэрэв тийм стандарт байдаггүй бол тохируулга хийсэн үндэслэлийг баримтжуулж, энэ дүрмийн 171.71 зүйлд заасан журмын дагуу тайлан, бүртгэл үйлдэж хадгална;

2/ шалгах төхөөрөмж бүр өөрийн тохируулгыг үзүүлэх индикатортай байх;

3/ шалгалт тохиргоо, хэмжилтийн төхөөрөмжид дараах хяналтыг байнга тавьж байна:

3.1 тохируулгыг нь алдагдуулахгүй байхаар хамгаалан, тоноггосон байх;

3.2 ашиглах, зөөх, хадгалж хамгаалах явцад нарийвчлал нь өөрчлөгдөхгүй байх.

(г) Хэрэв өөр байгууллагын шалгалт тохиргоо, хэмжилтийн төхөөрөмжийг ашиглан байгууламжийн техникийн ажиллагааны хэмжилтийг гүйцэтгэх бол тухайн төхөөрөмж нь энэ зүйлийн (в)-д заасан шаардлагуудыг хангасан байна.

<p><u>(2) тогтоосон үечлэлд.</u></p>		
